



**Дэлхийн Театрын Өдөр 2020 Мэндчилгээ дэвшүүлэгч**

**Мэндчилгээ дэвшүүлэгчийн намтар: Шахид НАДЕЕМ, Пакистан**

Монгол орчуулга

---

## **Шахид Надеем**

Жүжгийн зохиолч

Шахид Надеем нь Пакистаны шилдэг жүжгийн зохиолч төдийгүй алдарт Ажока театрын дарга юм.

Шахид Надеем нь 1947 онд Кашмирийн Сопоред төрсөн. Кашмир мужийн маргаанаас үүдэлтэй Энэтхэг, Пакистаны дайны дараа 1948 онд эцэг эх нь шинээр тусгаар тогтносон Пакистан улс руу дүрвэн нүүснээр тэрээр дөнгөж нэг ойтойдоо дүрвэгч цагаач болжээ. Тэр Пакистаны Лахоре хотноо амьдарч, тэндхийн Пенжаб их сургуулиас сэтгэл судлалын магистрын зэрэг хүртжээ. Тэр оюутан байхдаа анхны жүжгийн зохиолоо бичиж байсан боловч жүжгийн зохиолоор Лондонд улс төрийн цөллөгт байхдаа, тухайн үед Мадееха Гаухарын байгуулсан Пакистаны тэрс үзэлт Ажока хэмээх театрт зохиол бичиж өгөх болсон цагаас тууштай дагнах болсон байна. Мадееха Гаухар нь театрын анхдагч, шаргуу тэмцэгч уран бүтээлч ба хожим нь зохиолч түүнтэй гэр бүл болсон юм. Шахид Надеем 50 гаруй жүжгийн зохиолыг пенжаб болон урду хэлээр бичсэнээс гадна Брехтийн жүжгүүдээс сэдэвлэсэн хэд хэдэн жүжгийг бичжээ.

Тэрээр Пакистаны телевизэд продюсер болон удирдлагын зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. Хэд хэдэн цэргийн дэглэмийн засаглалын үед тэрээр цэргийн дарангуйлалыг эсэргүүцсэн шалтгаанаар баривчлагдан гурван удаа шоронд хоригдож байсан ба Амнести Интернэйшнл байгууллага түүнийг *оюун санааны хоригдол* хэмээн үзэн анхааралдаа авч байв. Алдарт Мианвали шоронд байхдаа тэр амралтын өдрүүдэд зориулан жүжиг бичиж хамт хоригдож буй хоригдлуудын хамт найруулан тэдэнд тоглож үзүүлдэг байв. Хожим тэрээр Амнести Интернэйшнл байгууллагын Ази, номхон далайн бүсийн харилцаа холбооны мэргэжилтэн болон кампанит ажлуудын зохицуулагчаар ажиллах болжээ. Мөн тэрээр Гетти судалгааны хүрээлэн, Интернэйшнл пен, АНУ болон Ардчилалын төлөөх үндэсний тусламжийн сангийн гишүүн болов. Тэр мөн Хил хязгааргүй театр сүлжээний гишүүн аж.

Шахид Надемын жүжгүүд Пакистан, Энэтхэгт өргөнөөр хэвлэгдэн, мөн тайзнаа тоглогдож байна. Түүний жүжгүүд, ялангуяа Булха жүжгийг Лондонгийн Хаммерсмит театрт, Шотландын Гласгоу хотын Трамвэй театрт, Данийн Хэлсигнорт, Амрика Чало жүжгийг нь Вашингтоны Жорж Тауны Тайзны урлагийн Давис төвд, Бала хаан жүжгийг нь Норвегийн Осло хотын Блак Бокс театрт, Буркаваганза жүжгийг нь АНУ-д Сан Франциско дахь Эмэгтэйчүүдийн театр Бравод, Цагаатгал жүжгийг нь Санта Моникагийн Хайвэйс болон Нью Йоркийн Театр Роуд, Дара жүжгийг нь Лондогийн Литтлетон театрт болон АНУ-ын Чапел Хилл дэх Хойд Каролиний их сургуулийн тайзнаа тоглосон байна.

Түүний жүжгүүдийг англи хэлнээ орчуулан Оксфордын их сургуулин хэвлэлийн газар, Ник Херн Паблишерс болон хэд хэдэн хэвлэлийн газрууд гаргажээ. Түүнийг Пакистаны ерөнхийлөгчийн медалиар 2009 онд Тайзны Бахархал болсон хэмээн олгосон байна. Тэрээр мөн Энэтхэг, Пакистанд болсон Энхийн төлөө театр фестивалиудад тайзны болон телевизийн жүжгүүд найруулан оролцож байв. Тэр Пакистан болон Энэтхэгийн томоохон сонины газрууд болон ВВС-ийн Урду хэлний редакцид ажилладаг байна. Лахоре музей, пенжаб уламжлал, яруу найрагч Икбал ба зураач Садекайн зэрэг соёлын сэдвүүдээр баримтат нэвтрүүлгүүдийн продюсерээр ажилласан аж.

Шахид Надемын жүжгүүд нь нийгмийн асуудлыг хурцаар бодитой дэвшүүлэн тавьдаг төдийгүй шашны хэт даврагсад, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, бага жижиг үндэстнүүдийг ялгаварлан гадуурхах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, уур амьсгалын өөрчлөлт, энх тайван болон суфизм зэрэг хориотой ч гэмээр сэдвүүдийг хөндсөн байдгаар алдартай. Түүний нилээд хэдэн жүжиг нь зүүн азийн салан тусгаарлах бодлого болон тус бүс нутгийн соёлын өвийн харилцан хамаарлын асуудлыг хөндсөн байдаг. Тэр орчин үеийн нийгэм, улс төрийн асуудлыг уламжлалт хэлбэр болон ардын өв соёлтой гайхалтай хослуулж сонирхолтой бөгөөд сэтгэхүйн хувьд өгөөжтэй театрын бүтээл туурвиж чаддаг хосгүй авьяастай. Түүний театрын бүтээлүүдэд хөгжим чухал байр суурь эзэлдэг. Тайзны урлагийн Ажока институт болон Лахорын Урлаг, соёлын хүрээлэнд тэрээр зохиол бичих урлагийн хичээл зааж байна.